

БАТЛАВ: НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ М. ЭНЭБИШ

НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго: "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийх, ажлын гүйцэтгэлийг сайжруулах, ажлын хариуцлага, чанарыг өндөржүүлэх.

Ажиллах ерөнхий чиглэл:

- ✓ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
- ✓ Санхүүгийн үйл ажиллагаа
- ✓ Архив баримт бичиг
- ✓ Албан хаагчдын хувийн хэргийн баяжилт

Шалгалт хийх хугацаа: 2025 оны 04 сарын 22-ны өдөр

Дотоод хяналтаар багийн шалгалт хийх ажлын чиглэл:

Албан хаагчид өөрийн хариуцсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон байгууллагын холбогдох эрх зүйн актын гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний дагуу жилийн тайланг товч тодорхой, тоо баримттай, үнэлгээ дүгнэлттэй гаргах

- ✓ Холбогдох эрх зүйн актыг бүрэн эхээр нь хавтаслан нэгтгэж байгууллагын дотоод хяналт шалгалтын комисст өгөх
- ✓ Шалгалтын комисс удирдамж, төлөвлөгөөний дагуу материалуудыг хянаж үзэн асуух шаардлагатай зүйлсийг тухай бүр тодруулж шалгалтыг зохион байгуулна.
- ✓ Шалгалтын төгсгөлд дүнгийн хурал хийж, цаашид анхаарах асуудлын талаар заавар зөвлөмж өгч ажиллана.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН КОМИСС

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ХҮРЭЭНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

Сүхбаатар аймгийн Насан туршийн суралцахуйн дотоод хяналтын комисс нь "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт,

захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, доорх зөвлөмжийг өгч байна.

Зөвлөмж:1

Шилэн дансны 6 мэдээлэл хоцроосон учир нөхөж байршуулах. /Нягтлан бодогч Б.Аззаяа /

Зөвлөмж:2

Насан туршийн суралцахуйн төвийн багш Б.Булгантөгс, нягтлан бодогч Б.Аззаяа нарын хувийн хэргийн хавтсанд баяжилт хийж, шинэчлэх. /НТСТ-ийн менежер П.Уянга/

Зөвлөмж:3

Насан туршийн суралцахуйн төвийн багш У.Наранжаргалын агуулахад байгаа байгууллагын эд хөрөнгө алдагдах эрсдэлтэй байсан учраас хадгалалт хамгаалалт сайтай газар байршуулах. /А.Батбаатар /

Зөвлөмж:4

Насан туршийн суралцахуйн төвийн 2, 3, 4 номерын өрөөний цахилгааны утас эрсдэл өндөр байгаа тул шинэчлэх. /Нийгмийн ажилтан А.Батбаатар /

Зөвлөмж:5

Байгууллагын захирлын А,Б тушаалыг ангилах, хавтаслах. /НТСТ-ийн багш Х.Булгантөгс/

Зөвлөмж:6

Аймгийн Засаг дарга Сумын Засаг дарга нартай байгуулах 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд” тусгагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр- III"-ийн хэрэгжилт 60 хувьтай учир эрчимжүүлэх шаардлагатай. /НТСТ-ийн багш У.Наранжаргал/

2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 3-ны өдрийг хүртэл 7 хоногийн хугацаанд дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН КОМИСС

**ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗӨВЛӨМЖИЙН МӨРӨӨР ХИЙЖ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Сүхбаатар аймгийн Насан туршийн суралцахуйн дотоод хяналтын комисс нь "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 3-ны өдрийг хүртэл 7 хоногийн хугацаанд доорх зөвлөмжүүдийг өгсөн. Тус зөвлөмжийн хүрээнд ажлын хэсэг гарч илэрсэн асуудлыг шийдвэрлэх, эрсдэлийг бууруулах, байх ёстой шалгуурт хүргэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажилласан.

ЗӨВЛӨМЖ 1: Шилэн дансны 6 мэдээлэл хоцроосон учир нөхөж байршуулах.

Зөвлөмжийн хэрэгжилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эхний хагас жилийн байдлаар шилэн дансанд хоцроосон 6 мэдээллийг нөхөж байршуулсан. Нийт 68 мэдээллийг <https://shilendans.gov.mn/> цахим хуудсаар иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгосон.

ЗӨВЛӨМЖ 2: Насан туршийн суралцахуйн төвийн багш Б.Булгантөгс, нягтлан бодогч Б.Аззаяа нарын хувийн хэргийн хавтсанд баяжилт хийж, шинэчлэх.

Зөвлөмжийн хэрэгжилт:

Насан туршийн суралцахуйн төвийн багш Б.Булгантөгс, нягтлан бодогч Б.Аззаяа нарын хувийн хэргийг шинэчилсэн. Нэмэлтээр сургалтад хамрагдсан гэрчилгээ, намтар түүхийг нэмэлтээр хийж гүйцэтгэсэн.

Зөвлөмж:3 Насан туршийн суралцахуйн төвийн багш У.Наранжаргалын агуулахад байгаа байгууллагын эд хөрөнгө алдагдах эрсдэлтэй байсан учраас хадгалалт хамгаалалт сайтай газар байршуулах.

Зөвлөмжийн хэрэгжилт:

Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгө ашиглалтын бүртгэлийн маягт карттай нь тулган, нүдээр харж үндсэн хөрөнгө, тавилга эд хөрөнгийн эдэлгээний чанар, өнгө үзэмж ашиглалт зэргийг шалган тоо ширхгээр тулган тоолсон. Тооллогын комисс үзлэг тооллого хийж, эд хөрөнгийн зургийг авч цахим системд байршуулсан. Тооллогоор дутсан эд хөрөнгө байхгүй байна. Хувь хүний агуулахад байсан байгууллагын эд хөрөнгийг машинаар зөөж, өөрийн эзэмшлийн грашд байршуулсан.

Зөвлөмж:4 Насан туршийн суралцахуйн төвийн 2, 3, 4 номерын өрөөний цахилгааны утас эрсдэл өндөр байгаа тул шинэчлэх.

Зөвлөмжийн хэрэгжилт:

Насан туршийн суралцахуйн албан хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор өрөө бүрт цахилгааны уртасгагч авч өгсөн.

Зөвлөмж:5 Байгууллагын захирлын А,Б тушаалыг ангилах, хавтаслах.

Зөвлөмжийн хэрэгжилт:

Байгууллагын захирлын А,Б тушаал байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан тушаалыг ангилан 3 хадгаламжийн нэгж үүсгэн үдэж хавтасласан.

Зөвлөмж:6 Аймгийн Засаг дарга Сумын Засаг дарга нартай байгуулах 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд” тусгагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр- III"-ийн хэрэгжилт 60 хувьтай учир эрчимжүүлэх шаардлагатай.

Зөвлөмжийн хэрэгжилт

Насан туршийн суралцахуйн төвийн багш У.Наранжаргал амаржсан байсан тул

"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр- III"-ийн хэрэгжилт 60 хувьтай эрчимжүүлэх шаардлагатай байсан. Багш У.Наранжаргал нь 4 сарын 1 нд ажилдаа орсон бөгөөд 2025 оны нэг ба хоёрдугаар улиралд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хүрээнд танхим болон цахим хосолсон сургалт, үйл ажиллагааг 5 төрлөөр зохион байгуулж давхардсан тоогоор 201 иргэнийг хамруулж 406,000 төгрөг зарцуулсан. Хэрэгжилт 95 хувьтай ахисан байна.

Дүгнэлт:

Насан туршийн боловсрол төвд хамаарах эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг 2025 оны үйл ажиллагааны тайлан, үр дүнг нотлох холбогдох материалуудыг ашиглан гүйцэтгэсэн.

Сүхбаатар аймгийн Насан туршийн суралцахуйн дотоод хяналтын комисс нь "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, 6 зөвлөмж өгсөн.

Тус зөвлөмжийн хүрээнд ажлын хэсэг гарч илэрсэн асуудлыг шийдвэрлэх, эрсдэлийг бууруулах, байх ёстой шалгуурт хүргэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжилтийг ханган ажилласан. Насан туршийн суралцахуйн төвийн багш У.Наранжаргал амаржсан байсан тул "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр- III"-ийн хэрэгжилт 60 хувьтай эрчимжүүлэх шаардлагатай байсан.

Багш У.Наранжаргал нь 4 сарын 1 нд ажилдаа орсон бөгөөд 2025 оны нэг ба хоёрдугаар улиралд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хүрээнд танхим болон цахим хосолсон сургалт, үйл ажиллагааг 5 төрлөөр зохион байгуулж давхардсан тоогоор 201 иргэнийг хамруулж 406,000 төгрөг зарцуулсан. Хэрэгжилт 95 хувьтай ахисан байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт -90 хувьтай байна. 9 зорилт, 36 арга хэмжээний хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнасан. Ноцтой зөрчил байхгүй. Тайлагналт товч, оновчтой болсон байна.

НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН КОМИСС